



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 752

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 27,360,000.00 (хорин долоон сая гурван зуун жаран мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Дорноговь-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, “Дорноговь-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарын шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13201667

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны  
өдрийн 752 дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн  
балансаас "Дорноговь-А33А" ТӨХК-ийн балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн  
жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо шир хэг	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөгөөр)	Цаашид ашиглах хугацаа
1	Суудлын автомашин, Самсунг маркийн УНА 89-48 улсын дугаартай, арлын дугаар- KNMC4C2HMAP052876	2010/2010	1	27,360,000.00	4,560,000.00	1
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1 (нэг)</b>	<b>(хорин долоон сая гурван зуун жаран мянга)</b>	<b>(нэг сая таван зуун жаран мянга)</b>	